



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-5

1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд мэдээлэх

4

2. Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

4-5

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 02-ны өдөр /Даваа гараг/ -ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 17 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, Л.Гантөмөр, Г.Дамдинням, Т.Доржханд, Г.Лувсанжамц, П.Наранбаяр, Ч.Номин, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа, Г.Хосбаяр, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр, Д.Энхтуяа, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Н.Алтаншагай, Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Х.Болормаа, Х.Булгантуяа, Д.Бум-Очир, Б.Дэлгэрсайхан, Д.Жаргалсайхан, Ч.Лодойсамбуу, Ц.Мөнхбат, Т.Мөнхсайхан, Э.Одбаяр, Г.Очирбат, Б.Түвшин, Ч.Ундрам, Н.Учрал, Ж.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Батчимэг, А.Ганбаатар, Г.Ганбаатар, Б.Жаргалан, З.Мэндсайхан, Н.Номтойбаяр;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, С.Лүндэг, Ц.Мөнхтуяа, Ц.Туваан;

Хоцорсон: С.Амарсайхан-03 минут Т.Аубакир-03 минут, Х.Баттулга-01 минут, Д.Ганбат-02 минут, Х.Ганхуяг-01 минут, Б.Заяабал-03 минут, Г.Тэмүүлэн-02 минут, С.Цэнгүүн-01 минут.

Нэг.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаар нэгдсэн хуралдаанд мэдээлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн

төслийг Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв./14:18/

Хоёр.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болохыг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 20
Бүгд: 70
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 06 минут үргэлжилж, 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР /ДАВАА ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 64 гишүүн ирцэд бүртгэгдэж, чуулганы нэгдсэн хуралдааны ирц хүрсэн байна.

2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар 2 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийнэ.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газар 2024 оны 12 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн. Төсвийн байнгын хороонд хуваарилсан байна.

14.18 цаг

Дараачийн асуудалд оръё.

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төслийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа. Одоо Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулахаар байгаа.

Санал хураалтаас өмнө ирц бүртгэлийн нэг санал хураалт явуулъя. Танхимд байгаа гишүүдийг тоолъё. Ирц бүртгэлийн санал хураалт.

Нийт 67 гишүүн ирцэд бүртгэгдсэнээс 48 гишүүн танхимд саналаа өгсөн байна аа. Ингээд санал хураалтыг эхлүүлье.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 71.4 хувь нь яаралтай хэлэлцэхийг дэмжлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул дууссан тул хуралдааныг өндөрсгөхийг мэдэгдье. Төсвийн байнгын

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*